



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2024 оны 08 сарын 18 өдөр

Дугаар А/236

Улаанбаатар хот

┌ Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай ┐

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэг, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/320 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Өрхийн эрүүл мэндийн төвийн дүрэм”-д нэмэлт, өөрчлөлт оруулсугай.

2. Өрхийн эрүүл мэндийн төвийн дүрмийн 1.9, 2.5, 4.3 дахь хэсгийн 4.3.1 дахь заалтыг дор дурдсанаар өөрчилсүгэй.

2.1. Өрхийн эрүүл мэндийн төвийн дүрмийн 1.9, 1.11 дэх заалтыг нэгтгэн “Өрхийн эрүүл мэндийн төвд ногдох иргэний доод хязгаар нь аймаг орон нутагт 8000-аас доошгүй, нийслэлд 10000-аас доошгүй байх бөгөөд хүн амын тоо, тусламж, үйлчилгээний эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн Өрхийн эрүүл мэндийн төв нь салбар, нэгж байгуулан ажиллаж болно” гэж;

2.2. Өрхийн эрүүл мэндийн төвийн дүрмийн 2.5 дахь заалтыг “Төвийн дарга нь 1500-1800 иргэнд 1 өрхийн эмч, 1 өрхийн сувилагч ноогдохоор тооцон өрхийн эмч, сувилагчийн орон тоог баталж, харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын өвчлөлийн бүтэц, эрэлт хэрэгцээнд тохируулан туршлагатай, эмчийг гэрээгээр болон үндсэн ажилтнаар ажиллуулах” гэж өөрчлөх;

2.3. Өрхийн эрүүл мэндийн төвийн дүрмийн 4.3.1 дэх заалтыг “Анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль төгссөн, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, өрхийн эмчээр 3-аас доошгүй жил ажилласан, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг мөрддөг, манлайлах, харилцааны ур чадвартай, өрхийн анагаах ухаан болон ерөнхий мэргэшил судлалаар мэргэшсэн бол давуу тал болно” гэж өөрчлөх;

3. Тушаалыг мөрдүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр)-т даалгасугай.

САЙД

Э.БАТШУГАР